

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/206/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogt.v@audit.gov.mn Аудитор : Б.Отгонцэцэг Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал: Л.Насанбуян Утас:99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Төлбөрийн акт.....	22
5.2 Албан шаардлага	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨЯ	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам
НА	Нотлох ажил
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СНАГ	Санхүү-Нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/404
танай _____-ны № _____-т

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Г.УУГАНЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгаагүй, 418,806.8 мянган төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгэх худалдан авах ажиллагааг хэсэгчлэн хувааж 18 харилцагчтай 23 шууд худалдан авах гэрээ байгуулж, нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаас зайлсхийсэн;
- Нэр бүхий 3 компанитай нийт 56,390.5 мянган төгрөгийн засварын ажил гүйцэтгүүлэх, гал тогооны ширээ сандал хийлгэх гэрээ байгуулж, төлбөрийг бүрэн төлсөн боловч ажлууд хийгдээгүй, тайлант оны зардлаар тайлагнасан;
- Өмнөх онд эмийн үнэд 96,600.0 мянган төгрөгийг шилжүүлж он дамжуулан авлагаар бүртгэсэн бөгөөд эмийг хүлээж аваагүй;
- "Үйлчлүүлэгчид, ажилтнуудын эмчилгээний халуун хоол"-ны үйлчилгээг худалдан авах тендер зарлаж "Итгэлт анд" ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулж ажилладаг боловч гал тогооны бүх тоног төхөөрөмж болон ажилчдын цалин урамшуулал, ашиглалтын бүх зардлыг төсвөөс төлж, нийт 458,295.2 мянган төгрөг зарцуулсан;
- "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний санхүүжилтээс тайлант онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй арга хэмжээнд 25,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 32 дугаар зүйлийн 32.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дах заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний 2025 онд хэрэгжих арга хэмжээний батлагдсан төсвөөс Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/317 дугаар тушаалаар тус төвд 1,356,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эрхийг шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус төвийн ажилтнууд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулиар хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаарагддаг бөгөөд 6 цаг ажиллаад 18 цагаар амарч богиносгосон цагаар ажиллахаар зохицуулагдсан байна. Тус төвийн ээлжийн ажилчдын сард ажилласан илүү цаг нь Төрийн албаны цалингийн нэгдсэн системд оруулсан шөнийн болон илүү цагийн дээд хязгаараас давсан тул тайлант оны 12 дугаар сард эмнэлгийн тусламж үйлчилгээний нэмэгдэл хөлс гэсэн баганаар илүү цагийн зөрүү нэмэгдлийг бодож олгосон байна.

Бусад асуудал

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, судалгаа, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,215,916,523.43	2,941,817,154.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	166,025,832.74	237,762,197.34
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	166,025,832.74	237,762,197.34
31210	Төгрөг	166,025,832.74	237,762,197.34
31211	Төрийн сангийн харилцах	166,025,832.74	237,762,197.34
33	АВЛАГА	3,430,729,272.83	1,327,377,987.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	830,364.20	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,427,943,005.63	1,327,377,987.30
33500	Бусад авлага	1,955,903.00	-
33510	Байгууллагаас авах авлага	1,955,903.00	-
34	УРЬДЧИЛГАА	105,735,300.00	99,735,300.00
34600	Урьдчилж гарсан зардал	105,735,300.00	99,735,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,513,426,117.86	1,276,941,669.91
35100	Түүхий эд материал	331,116,340.61	297,312,953.70
35110	Тусгай зориулалттай материал	39,521,127.50	60,648,739.32
35130	Эм боох материал	291,595,213.11	236,664,214.38
35400	Хангамжийн материал	1,182,309,777.25	979,628,716.21
35410	Бичиг хэргийн материал	26,228,580.00	28,662,652.00
35420	Аж ахуйн материал	47,035,951.60	120,229,359.48
35430	Сэлбэг хэрэгсэл	5,988,570.00	3,546,370.00
35440	Түлш, шатах тослох материал	208,918,280.00	39,077,714.00
35450	Барилгын засварын материал	36,055,473.01	63,783,461.92
35460	Хүнсний материал	16,483,180.79	0.04
35470	Бусад хангамжийн материал	841,599,741.85	724,329,158.77
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,305,070,409.81	19,378,926,429.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,305,070,409.81	19,378,926,429.97
39200	Биет хөрөнгө	19,351,067,859.97	18,440,911,355.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,198,481,329.82	17,198,481,329.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,866,675,228.09)	(3,317,400,160.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	209,674,550.00	202,352,086.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,684,091.74)	(32,692,247.36)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,543,484,481.69	4,458,382,005.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,826,059,444.78)	(1,876,222,872.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,575,191,428.53	1,445,465,490.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(517,306,171.30)	(585,054,530.65)
39209	Зам, гүүрний байгууламж	1,494,427,415.00	1,493,038,215.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(456,218,855.22)	(575,293,494.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,789,407.00	50,519,138.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,036,960.94)	(20,663,604.42)
39300	Биет бус хөрөнгө	954,002,549.84	938,015,074.76
39301	Программ хангамж	89,841,900.00	89,841,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,807,750.16)	(33,795,225.24)
39303	Бусад биет бус хөрөнгө	881,968,400.00	881,968,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	25,520,986,933.24	22,320,743,584.52

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,595,975,624.51	3,685,488,738.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,595,975,624.51	3,685,488,738.92
41300	Өглөг	1,595,975,624.51	3,685,488,738.92
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,311,382,959.23	3,007,738,838.08
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	236,329,899.00	557,630,615.20
41360	Бусад өглөг	48,262,766.28	120,119,285.64
41361	Байгууллагад төлөх өглөг	45,832,840.50	115,620,796.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,429,925.78	4,498,489.64
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,925,011,308.73	18,635,254,845.60
51	Засгийн газрын хувь оролцоо	23,925,011,308.73	18,635,254,845.60
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,876,381,555.29	7,876,381,555.29
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	7,876,381,555.29	7,876,381,555.29
51200	Хуримтлагдсан үр дүн	6,558,789,373.16	1,269,032,910.03
51210	Өмнөх үеийн үр дүн	6,227,672,387.68	6,558,789,373.16
51220	Тайлант үеийн үр дүн	331,116,985.48	(5,289,941,265.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,489,840,380.28	9,489,840,380.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	25,520,986,933.24	22,320,743,584.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	24,489,940,427.83	25,565,523,567.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,100,833,450.83	25,565,523,567.23
120	Нийтлэг татварын бус орлого	10,100,833,450.83	11,616,302,256.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,416,825,992.31	10,377,925,387.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	811,746,122.21	1,044,341,175.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,605,079,870.10	9,333,584,212.07
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,370,546,187.29	1,180,952,591.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	313,461,271.23	57,424,277.96
122	Тусламжийн орлого	-	13,949,221,311.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	13,949,221,311.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	13,949,221,311.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	13,949,221,311.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,389,106,977.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,389,106,977.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,389,106,977.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	24,158,823,442.35	30,718,420,105.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,158,823,442.35	30,718,420,105.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,903,885,449.65	30,110,982,178.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,917,541,250.16	17,698,702,341.52
210101	Үндсэн цалин	7,086,383,635.05	9,045,109,791.15
210102	Нэмэгдэл	5,207,255,465.51	6,411,059,101.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	586,090,000.00	1,063,876,913.77
210104	Урамшуулал	1,037,812,149.60	1,178,656,535.29

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,747,075,773.98	2,196,801,778.18
210201	Тэтгэврийн даатгалын зардал	1,189,482,476.70	1,474,666,595.79
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	140,773,080.84	196,629,325.36
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	95,429,603.80	105,111,652.34
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	49,423,604.60	83,497,402.71
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	271,967,008.04	336,896,801.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	652,202,809.73	1,105,138,602.95
210301	Гэрэл, цахилгаан	215,964,758.89	254,956,172.38
210302	Түлш, халаалт	249,416,935.00	683,719,179.58
210303	Цэвэр, бохир ус	186,821,115.84	166,463,250.99
2104	Хангамж, бараа материалын зардал	365,804,306.81	848,610,134.18
210401	Бичиг хэрэг	48,999,056.00	88,095,228.00
210402	Тээвэр, шатахуун	115,453,327.00	33,886,482.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,575,789.86	38,097,713.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	152,631,261.45	109,550,194.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,144,872.50	160,365,659.10
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	106,623,914.00
210408	Бараа материал акталсны зардал	-	311,990,944.08
2105	Нормативт зардал	3,378,929,323.05	3,356,468,882.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,015,025,007.45	1,777,911,463.35
210502	Хоол, хүнс	1,348,761,089.10	1,577,027,919.15
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,143,226.50	1,529,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	566,627,425.08	499,995,836.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	57,912,780.00	7,600,000.00
210602	Тавилга	-	18,254,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	25,826,200.00	2,800,000.00
210604	Урсгал засвар	482,888,445.08	471,341,836.09
2107	Томилолт, зочны зардал	122,468,000.00	40,774,500.00
210701	Гадаад албан томилолт	-	1,291,500.00
210702	Дотоод албан томилолт	122,468,000.00	39,483,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	744,611,250.66	715,107,805.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	700,054,692.66	640,486,922.42
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	10,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,531,900.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,460.00	245,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,041,400.00	62,399,883.00
210807	Газрын төлбөр	7,008,956.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,677,842.00	1,610,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,408,625,310.18	3,649,382,298.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	320,325,828.00	1,317,127,608.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,796,863.45	166,739,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,071,502,618.73	2,165,515,689.56
13	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	254,937,992.70	607,437,927.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	254,937,992.70	607,437,927.06
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	180,025,492.70	541,192,177.06
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	74,912,500.00	66,245,750.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	331,116,985.48	(5,152,896,538.73)

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	137,044,726.48
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	128,622,504.32
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	8,422,222.16
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	8,422,222.16
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(137,044,726.48)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	331,116,985.48	(5,289,941,265.21)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	21,054,326,507.6	26,427,711,716.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,415,198,680.31	26,427,711,716.40
120	Нийтлэг татварын бус орлого	8,415,198,680.31	10,377,925,387.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,415,198,680.31	10,377,925,387.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	802,909,296.00	1,044,341,175.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,612,289,384.31	9,333,584,212.07
122	Тусламжийн орлого	-	16,049,786,329.33
1221	Хандив тусламж /дотоод/	-	16,049,786,329.33
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	16,049,786,329.33
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	16,049,786,329.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,639,127,827.40	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,639,127,827.40	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,639,127,827.40	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,888,910,418.66	26,160,511,506.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,888,910,418.66	26,160,511,506.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,636,971,425.96	25,553,073,579.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,114,310,600.58	16,646,566,984.04
210101	Үндсэн цалин	6,114,026,685.34	7,768,354,232.98
210102	Нэмэгдэл	5,430,497,432.26	7,032,605,493.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	545,355,243.39	771,381,678.43
210104	Урамшуулал	1,024,431,239.59	1,074,225,579.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,244,018,517.73	1,546,283,107.15
210201	Тэтгэврийн даатгалын зардал	914,156,411.12	1,128,285,107.15
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	84,230,740.08	134,989,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	41,460,854.48	86,504,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	42,035,651.09	87,524,700.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	162,134,860.96	108,979,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	778,979,074.73	850,347,618.31
210301	Гэрэл, цахилгаан	209,864,758.89	254,956,172.38
210302	Түлш, халаалт	382,293,200.00	428,928,194.94
210303	Цэвэр, бохир ус	186,821,115.84	166,463,250.99
2104	Хангамж, бараа материалын зардал	335,488,376.11	268,369,472.00
210401	Бичиг хэрэг	29,334,410.00	37,368,890.00

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	110,254,079.00	28,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,918,986.86	38,097,713.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,815,464.25	110,389,354.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	44,165,436.00	53,913,515.00
2105	Нормативт зардал	3,369,257,338.70	3,449,446,770.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,849,846,059.00	1,714,372,710.00
210502	Хоол, хүнс	1,433,216,079.70	1,560,613,060.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	86,195,200.00	174,461,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	606,294,490.00	501,726,224.98
210601	Багаж, техник, хэрэгсэл	98,772,900.00	25,615,500.00
210602	Тавилга	19,272,000.00	23,660,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,718,600.00	23,191,699.98
210604	Урсгал засвар	473,530,990.00	429,258,325.00
2107	Томилолт, зочны зардал	121,810,000.00	40,774,500.00
210701	Гадаад албан томилолт	-	1,291,500.00
210702	Дотоод албан томилолт	121,810,000.00	39,483,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	767,347,100.07	732,807,037.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	687,346,282.07	658,524,854.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	10,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,531,900.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,460.00	245,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	47,649,500.00	60,533,183.00
210807	Газрын төлбөр	7,008,956.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,514,002.00	3,138,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	299,465,928.04	1,516,751,865.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	282,550,444.00	1,348,849,265.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,915,484.04	167,902,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,938,992.70	607,437,927.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	251,938,992.70	607,437,927.06
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	180,025,492.70	541,192,177.06
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	71,913,500.00	66,245,750.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	165,416,089.02	267,200,209.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	209,192,800.00	195,463,845.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	209,192,800.00	195,463,845.00
2200	Дотоод эх үүсвэрээр	209,192,800.00	195,463,845.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	209,192,800.00	195,463,845.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(209,192,800.00)	(195,463,845.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(43,776,710.98)	71,736,364.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	209,802,543.72	166,025,832.74
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	166,025,832.74	237,762,197.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,876,381,555.29	9,489,840,380.28	6,227,672,387.68	23,593,894,323.25
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,876,381,555.29	9,489,840,380.28	6,227,672,387.68	23,593,894,323.25
9	Тайлант үеийн үр дүн	-	-	331,116,985.48	331,116,985.48
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,876,381,555.29	9,489,840,380.28	6,558,789,373.16	23,925,011,308.73
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	184,802.08	184,802.08
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,876,381,555.29	9,489,840,380.28	6,558,974,175.24	23,925,196,110.81
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,289,941,265.21)	(5,289,941,265.21)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,876,381,555.29	9,489,840,380.28	1,269,032,910.03	18,635,254,845.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	28,796,105,400.00	26,427,711,716.40	2,368,393,683.60	91.8
12	Татварын бус орлого	28,796,105,400.00	26,427,711,716.40	2,368,393,683.60	91.8
120	Нийтлэг татварын бус орлого	10,542,285,800.00	10,377,925,387.07	164,360,412.93	98.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,036,309,900.00	1,044,341,175.00	(8,031,275.00)	100.8
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	9,505,975,900.00	9,333,584,212.07	172,391,687.93	98.2
122	Тусламжийн орлого	18,253,819,600.00	16,049,786,329.33	2,204,033,270.67	87.9
122001	Хандив тусламж /дотоод/	18,253,819,600.00	16,049,786,329.33	2,204,033,270.67	87.9
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,068,007,800.00	26,355,975,351.80	2,712,032,448.20	90.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,068,007,800.00	26,355,975,351.80	2,712,032,448.20	90.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,379,437,200.00	25,748,537,424.74	2,630,899,775.26	90.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,687,119,400.00	16,646,566,984.04	1,040,552,415.96	94.1
210101	Үндсэн цалин	9,657,264,000.00	7,768,354,232.98	1,888,909,767.02	80.4
210102	Нэмэгдэл	5,932,532,500.00	7,032,605,493.11	(1,100,072,993.11)	118.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	775,000,000.00	771,381,678.43	3,618,321.57	99.5
210104	Урамшуулал	1,322,322,900.00	1,074,225,579.52	248,097,320.48	81.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,135,545,300.00	1,546,283,107.15	589,262,192.85	72.4

**Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	1,395,587,400.00	1,128,285,107.15	267,302,292.85	80.8
210202	Тэтгэмжийн даатгал	184,989,500.00	134,989,600.00	49,999,900.00	73.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	92,494,700.00	86,504,700.00	5,990,000.00	93.5
210204	Ажилгүйдлийн даатгал	92,494,700.00	87,524,700.00	4,970,000.00	94.6
210205	Эрүүл мэндийн даатгал	369,979,000.00	108,979,000.00	261,000,000.00	29.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	850,348,300.00	850,347,618.31	681.69	100.0
210301	Гэрэл, цахилгаан	264,148,300.00	254,956,172.38	9,192,127.62	96.5
210302	Түлш, халаалт	441,200,000.00	428,928,194.94	12,271,805.06	97.2
210303	Цэвэр, бохир ус	145,000,000.00	166,463,250.99	(21,463,250.99)	114.8
2104	Хангамж, бараа материалын зардал	284,878,600.00	284,017,472.00	861,128.00	99.7
210401	Бичиг хэрэг	39,380,600.00	37,368,890.00	2,011,710.00	94.9
210402	Тээвэр, шатахуун	27,500,000.00	28,600,000.00	(1,100,000.00)	104.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,350,000.00	38,097,713.00	(19,747,713.00)	207.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,000,000.00	110,389,354.00	19,610,646.00	84.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	69,648,000.00	69,561,515.00	86,485.00	99.9
2105	Нормативт зардал	3,657,899,200.00	3,449,446,770.40	208,452,429.60	94.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,040,096,300.00	1,714,372,710.00	325,723,590.00	84.0
210502	Хоол, хүнс	1,424,802,900.00	1,560,613,060.40	(135,810,160.40)	109.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	193,000,000.00	174,461,000.00	18,539,000.00	90.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,097,260,600.00	648,525,469.98	448,735,130.02	59.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000,000.00	140,480,915.00	89,519,085.00	61.1
210602	Тавилга	185,000,000.00	53,652,930.00	131,347,070.00	29.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,280,600.00	23,191,699.98	88,900.02	99.6
210604	Урсгал засвар	658,980,000.00	431,199,925.00	227,780,075.00	65.4
2107	Томилолт, зочны зардал	44,117,400.00	40,774,500.00	3,342,900.00	92.4
210701	Гадаад албан томилолт	2,000,000.00	1,291,500.00	708,500.00	64.6
210702	Дотоод албан томилолт	42,117,400.00	39,483,000.00	2,634,400.00	93.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	797,268,400.00	732,807,037.08	64,461,362.92	91.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	673,553,400.00	658,524,854.08	15,028,545.92	97.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	300,000.00	1,700,000.00	15.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	365,000.00	245,000.00	120,000.00	67.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	66,000.00	66,000.00	50.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	98,154,000.00	60,533,183.00	37,620,817.00	61.7
210807	Газрын төлбөр	7,064,000.00	-	7,064,000.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,000,000.00	3,138,000.00	2,862,000.00	52.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,825,000,000.00	1,549,768,465.78	275,231,534.22	84.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,675,000,000.00	1,381,865,865.78	293,134,134.22	82.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000,000.00	167,902,600.00	(17,902,600.00)	111.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	688,570,600.00	607,437,927.06	81,132,672.94	88.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	688,570,600.00	607,437,927.06	81,132,672.94	88.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	578,953,800.00	541,192,177.06	37,761,622.94	93.5

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	109,616,800.00	66,245,750.00	43,371,050.00	60.4
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(271,902,400.00)	(71,736,364.60)	(343,638,764.60)	(26.4)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	271,902,400.00	(71,736,364.60)	343,638,764.60	(26.4)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	271,902,400.00	(71,736,364.60)	343,638,764.60	(26.4)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	166,025,832.74	(166,025,832.74)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	237,762,197.34	(237,762,197.34)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	841	-	0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	505	489	16	96.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	250	311	-61	
620003	Үйлчлэх ажилтан	254	177	77	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	505	486		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	251	311		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	254	177		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь эрхэм зорилгоо “Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанар, хүртээмжтэй үзүүлж, үйлчлүүлэгчдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ:

- Хэвтүүлэн эмчлэх тусламж: Хурц болон архаг явцтай сэтгэцийн эмгэг, донтолт, хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн стационар тусламж;
- Амбулаторийн тусламж: Эмчийн үзлэг, сэтгэл заслын зөвлөгөө, оношилгоо, лабораторийн шинжилгээ;
- Яаралтай тусламж: Сэтгэцийн хямрал, цочмог төлөв байдлын үеийн 24 цагийн тусламж;

2. Нийгмийн эрүүл мэнд ба сэргээн засах:

- Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлууд;
- Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг нийгэмшүүлэх, хөдөлмөр заслын үйлчилгээ;

3. Сургалт, судалгаа ба эрдэм шинжилгээ:

- Мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтууд;
- Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээний ажил, статистик мэдээллийн нэгдсэн санг удирдах.

Тус төв нь 2024-2027 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулан дараах 4 зорилтуудыг тавьж ажиллаж байна. Үүнд:

- Тусламж үйлчилгээнд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсөв санхүүгийн удирдлага, зохион байгуулалт, нөөцийн хуваарилалтыг зохион байгуулах;
- Хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөгжлийг тодорхойлогч нь байж, улсын хэмжээний лавлагаа дүгнэлт гаргах, эмнэл зүйн заавар, стандарт, хөтөч боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх, эмнэлгийн мэргэжилтэн сургах, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чадвартай болгон хөгжүүлнэ;
- Хүний нөөцийг үе шаттай хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан мөрдөж, ажиллах хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ;
- Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, судалгааны ажлын үр дүнг практикт өргөнөөр нэвтрүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”

Төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үнэллээ.

Тайлант онд тус төвийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны А/121 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилласан бөгөөд тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тус төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,200,243.3 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	166,025.8	237,762.2	71,736.4
Авлага	3,430,729.4	1,327,378.0	(2,103,351.4)
Урьдчилгаа	105,735.3	99,735.3	(6,000.0)
Бараа материал	1,513,426.1	1,276,941.7	(236,484.4)
Үндсэн хөрөнгө	20,305,070.4	19,378,926.4	(926,144.0)
Нийт хөрөнгө	25,520,986.9	22,320,743.6	(3,200,243.3)
Өр төлбөр	1,595,975.6	3,685,488.7	2,089,513.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23,925,011.3	18,635,254.8	(5,289,756.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	25,520,986.9	22,320,743.6	(3,200,243.3)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данстууд байна. Үүнд:

Дансны авлага 1,327,378.0 мянган төгрөг болж өмнөх оноос 2,103,351.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг барагдуулсантай холбоотой.

Бараа материалын данс нь худалдан авсан 3,630,167.6 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй авсан 57,424.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 3,612,085.4 мянган төгрөг, акталж, данс бүртгэлээс хассан 311,990.9 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 926,144.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд худалдан авсан 195,463.8 мянган төгрөг, ЭМЯ болон бусад иргэн, аж ахуйн нэгжээс үнэ төлбөргүй шилжүүлсэн нийт 91,379.6 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны 881 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 1,089,572.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож бүртгэсэн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 557 дугаар тогтоолоор 480,753.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 352,316.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг акталсан, А/53 дугаар тогтоолын дагуу 37,900.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 29,293.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй автомашиныг Хилийн цэргийн 0214 дүгээр ангид балансаас баланст шилжүүлсэн дүнгээр хасагдаж, тайлант хугацаанд 2,165,515.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос өсөхөд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 902,420.0 мянган төгрөгөөр, хувь хүний орлогын татварын өглөг 793,935.9 мянган төгрөгөөр, эм ханган нийлүүлэгч байгууллагад өгөх өглөг 557,630.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Өр төлбөр дансны үлдэгдэлд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 1,744,996.0 мянган төгрөг, хувь хүний орлогын татварын өглөг 1,262,742.8 мянган төгрөг, эм ханган нийлүүлэгч байгууллагад өгөх өглөг 557,630.6 мянган төгрөг, бусад байгууллага хүмүүст 120,119.3 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,289,756.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Пискус санхүүгийн программ, Няравын программ, Аутизмын оношилгооны тест, Дугаарлалтын систем, AI /Lunit NUC11TNK/, Рентген аппаратын программ CV-key, Сэтгэцийн сорилын аппликейшн, Архив лавлагаа бүртгэлийн систем, Дуудлага бүртгэлийн программ зэрэг нийт 89,841.9 мянган төгрөгийн өртөгтэй программ хангамжуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Санхүүгийн программын хөгжүүлэлт, засвар үйлчилгээний төлбөрт жилд 660.0 мянган төгрөг төлж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төв нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 15,615,558.7 мянган төгрөг, улсын төсвөөс 9,271,630.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,849,209.6 мянган төгрөг, нийт зарлагыг 26,736,399.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 285,791.2 мянган төгрөгөөр бууруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас 19,957,107.3 мянган төгрөг, улсын төсвөөс 5,915,439.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 578,061.5 мянган төгрөг, нийт зарлагыг 26,450,607.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас авах дүнг 1,703,287.7 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 3,590,536.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг 730,150.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт зардлыг 29,068,007.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 16,049,786.3 мянган төгрөг, улсын төсвөөс 8,814,777.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,563,148.0 мянган төгрөг, нийт 26,427,711.7 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 26,355,975.4 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь Үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,629,814.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 81,132.1 мянган төгрөг, хөтөлбөр төсөл дотоод урсгал зардлыг 1,001,085.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	29,068,007.8	26,355,975.4	2,712,032.4	90.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	19,822,664.7	18,192,850.1	1,629,814.6	91.8
80202	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	688,570.0	607,437.9	81,132.1	88.2
83601	Хөтөлбөр төсөл дотоод урсгал	8,556,773.1	7,555,687.4	1,001,085.7	88.3

2025 оны санхүүгийн тайлангийн аудитын үндсэн чиглэлийн дагуу хийсэн судалгааны үр дүнгийн талаар:

1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар

Тус төв нь 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Тус төв нь ажилчиддаа өдөрт 12.0 мянган төгрөгийн хоолны, 3.0 мянган төгрөгийн унааны хөнгөлөлт олгож, тайлант онд дээрх зардалд нийт 1,086,266.8 мянган төгрөг зарцуулсан байна.

3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн:

Тайлант онд тус төв нь гадаад томилолтын зардлаас БНСУ-ын Улсын их сургуулийн эмнэлгийн урилгаар 1 ажилтныг тус эмнэлгийн робот бронхоскопийн технологи, амьсгалын замын интервенцийн төвийн нээлтийн арга хэмжээнд оролцуулах арга хэмжээнд нийт 1,291.5 мянган төгрөг зарцуулсан байна.

4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:

Тайлант онд дараах сургалтуудад нийт 167,902.0 мянган төгрөг зарцуулсан. Үүнд:

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын сэтгэц, мэдрэл, донтолт эмгэгийн заавар буюу mhGAP багц сургалт;
- “Сэтгэцийн эрүүл мэнд 2025” амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх шийдвэр гаргах түвшний хэлэлцүүлэг, олон улсын эрдэм шинжилгээний хурал;
- Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургагч багшийн зардал;
- “Сэтгэц, мэдрэл, донтолтын тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх” сургалт;

- “Хөдөлмөрийн харилцааны соёл”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн сургалтууд;
- “Монгол Улс дах Амиа хорлолтын нөхцөл” сэдэвт сургалт;
- “Би сэтгэцийн эмч”, “Нийгмийн сэтгэл зүй”, “Эмчээ сонсое” зэрэг сургалтууд;
- “Донтох эмгэгтэй хүнд үзүүлэх Сэтгэц - нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээ”;
- “Байгууллагын соёл, ёс зүйн хандлага” сэдэвт сургалт.

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүн:

Нэр бүхий 11 байгууллага /сайт/-тай тус бүр 4,900.0 мянган төгрөгийн хэвлэл, мэдээллийн гэрээ байгуулж ажилласан байна. Энэ асуудлын талаар тайлангийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал хэсэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгааны үр дүн:

Тайлант онд тус хүрээлэнгийн хуучин удирдлага буруу шийдвэрээр ажлаас халагдсан, албан тушаалтны гомдлын дагуу Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны хурлын тэмдэглэлийг үндэслэн 3 сарын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг төсвөөс нөхөн олгож, төрд 9,539.7 мянган төгрөгийн хохирол учруулсан. Энэ хохирлыг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хариуцуулан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.5.2.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний 2025 онд хэрэгжих арга хэмжээний батлагдсан төсвөөс Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/317 дугаар тушаалаар тус төвд 1,356,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эрхийг шилжүүлсэн байна. Эрх шилжүүлсэн үндэсний хөдөлгөөний санхүүжилтийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Нийслэлийн Хан-Уул дүүрэгт нийгмийн сэтгэл зүйн сэргээн засах жишиг төвийг бий болгон ажиллуулж Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Сэтгэцийн Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулиудын холбогдох заалтуудыг удирдлага болгон архины хэрэглээний эмгэгтэй хүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлж байна. Тухайлбал:

- Архины донтох эмгэгийн оношилгоо
- Сэтгэл зүйн зөвлөгөө
- Бүлгийн сэдэлжүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ
- 12 алхамд суурилсан Миннесота донтох эмгэгийн сэтгэл заслын хөтөлбөр
- Танин мэдэхүйн зан үйлийг өөрчлөх сэтгэл заслын эмчилгээ
- Хөдөлмөр засал, ном, хөгжим, орчин, арт терапи зэрэг заслын эмчилгээ
- Иог, бясалгал болон ховс эмчилгээ
- Туслах болон дэмжих бүлгийн үйлчилгээ, сургалт

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа баривчлах байр, баривчлах төвд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн зэрэг шалтгааны улмаас шийтгэгдсэн этгээдийн зан үйлийг өөрчлөх сургалтыг 7 хоног бүр зохион байгуулдаг байна. Үүнд:

- Донтох эмгэгээр өвчилсөн иргэдийг эмчлэх салбар дундын цогц арга хэмжээг зохион байгуулах;
- Утаат тамхи болон электрон тамхины талаар бодлогын болон нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус төв нь 2025 онд нийт 5,201,079.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 23 нэр төрлийн төсөл арга хэмжээний худалдан авах төлөвлөгөө баталсан байна. Үүнээс нийт 3,466,579.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 нэр төрлийн бараа, үйлчилгээний худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтаар, 838,265.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй эм эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээгээр, 95,900.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 бараа, үйлчилгээний худалдан авах ажиллагааг шууд худалдан авахаар, 800,334.7 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар тус тус худалдан авахаар төлөвлөсөн байна.

Нээлттэй болон харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааны зарыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Тайлант онд нийт 1,719,068.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 2,106,562.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хангамжийн материал худалдан авсан ба үүнээс 989,677.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг цахим дэлгүүрээс, 441,200.0 мянган төгрөгийн бараа материалыг нээлттэй тендер шалгаруулалтаар, 1,718,938.8 мянган төгрөгийн бараа материалыг харьцуулалтын аргаар, 675,814.8 мянган төгрөгийн хангамж, бараа материалыг шууд худалдан авах аргаар худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хүрээлэнгийн үйл ажиллагааг сайжруулах, цалин хөлс, үндсэн хөрөнгө, нэмэлт төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ажу мэргэн аудит ХХК-ийн аудитор Д.Наранчимэг, гэрээт аудитор Л.Хонгорзул нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн, захирал Л.Насанбуян нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Отгонцэцэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 24,158,823.4 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 120,794.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг нэр төрлөөр нь баталж, батлагдсан төлөвлөгөөний дагуу холбогдох хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

НКСТ ЭРА ХХК-аар мэдээ, мэдээлэл, хэвлэл, контент хийлгэхээр гэрээ байгуулж 4,900.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлын гүйцэтгэл байхгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4-т *"Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй Мэдээ, мэдээлэл, хэвлэл, контент хийгээгүй “НКСТ ЭРА” ХХК-иар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 152 мэдээллээс 4 мэдээллийг, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 297,997.7 мянган төгрөгийн зарлагын 14 гүйлгээ, 26,163.0 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг тус тус байршуулаагүй, 3,279,244.2 мянган төгрөгийн зарлагын 177 гүйлгээ, 15,823,240.5 мянган төгрөгийн орлогын 42 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан, тушаал, шийдвэр зэрэг зарлагын гүйлгээний хавсралтуудыг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах төлөвлөгөөний дагуу 28 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 6 худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл дутуу, тендер үнэлэх журмын дагуу маягтуудыг нөхөж үнэлээг хийгээгүй, оролцогчийн санхүүгийн, хүний нөөцийн чадавхыг үнэлэхэд шаардлагатай нотлох баримтууд дутуу байна.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гуравдугаар бүлэгт зааснаар тендер хянан үзэх, үнэлэхтэй холбоотой нарийвчилсан харилцаанд энэ аргачлал, зааврыг баримтална" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг Сангийн сайдын баталсан холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгэж байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан шалгуурт тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэсэн болно.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 4,528,344.8 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 824,176.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан, 3,704,168.4 мянган төгрөгийн 9 зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 178,931.1 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт, 3,621,504.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгснөөс 165,307.9 мянган төгрөгийн 5 төлбөрийн актыг, 1,569,013.8 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, биелэлт 30.2 хувьтай байна. Үүнд:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	7	178,931.1	2	13,623.2	24.0
Албан шаардлага	3	3,621,504.3	2	2,052,490.8	66.7
Зөвлөмж	1	-	-	-	0.0
Нийт дүн	10	3,800,435.7	4	2,066,144.0	30.2

Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-г бүрэн хэрэгжүүлж байгааг шалгах;
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл үр дүнг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 1,517,749.0 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Өмнөх онуудад элэгдэл байгуулж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, актлагдаж данс бүртгэлээс хасагдсан болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоосон хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар хүлээн зөвшөөрч, тайлант оны санхүүгийн үр дүнг бууруулж тайлагнасан;
- Үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгө данснаас хассан гарзыг 25,834.9 мянган төгрөгөөр илүү тайлагнаж тайлант хугацааны үр дүнг бууруулсан;
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 850.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Тайлант онд худалдан авсан 19,882.0 мянган төгрөгийн үнэ бүхий 9 ш тоног төхөөрөмж, хивс зэргийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Аудитаар нийт 5,142,012.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 93,746.6 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 4,485,493.9 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 562,772.0 мянган төгрөгийн зөрчлийн хууль хяналтын байгууллагад шилжүүлэх 2 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн 5,142,012.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс 5,021,218.4 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй ажилтнуудад 7,456.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын “Журам батлах тухай” 2019 оны 5 дугаар тогтоолын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтууд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 8.7-д “Төвийн захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жилийн дараа ажилтанд дараах эрх үүснэ”, 8.7.2-т “Шагнал, урамшуулал авах”, 8.21.6-д “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад олгосон урамшууллыг нөхөн суутгаж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний санхүүжилтээс Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/236 дугаар тушаалаар баталсан “Үндэсний хөдөлгөөний хүрээнд” хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй шүдний эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэсэн арга хэмжээнд Шүдний эрүүл мэнд, боловсрол олгох дагинас үндэсний санд 19,862.0 мянган төгрөг, "РТА" ХХК-д 5,138.0 мянган төгрөг, нийт 25,000.0 мянган төгрөгийг хэдэн сард, хаана, хэдэн хүнд ямар үйлчилгээ үзүүлснийг нотлох анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, 20 дугаар зүйлийн 20.1.4-т *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"* гэсэн заалтууд болон Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/236 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүдний эрүүл мэнд, боловсрол олгох дагинас үндэсний сан болон "РТА" ХХК-аар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тус байгууллага нь 2025 оны 1-3 дугаар сард 3 компанитай "Өндөр цалгай транс" ХХК-д 19,375.5 мянган төгрөг, "ГОТИК ГОЛД РӨҮД" ХХК-д 18,761.0 мянган төгрөгийг засварын ажил гүйцэтгүүлэхээр, "Гранд локита" ХХК-д 18,254.0 мянган төгрөгийг гал тогооны ширээ, сандал хийлгэхээр "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, төлбөрийг 100 хувь шилжүүлсэн боловч эдгээр ажлууд өнөөдрийг хүртэл хийгдээгүй байхад тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 16 дугаар зүйлийн 16.5.1-д *"төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй "Өндөр цалгай транс" ХХК, "ГОТИК ГОЛД РӨҮД" ХХК, "Гранд локита" ХХК-аар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 104,394.9 мянган төгрөг хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д *"даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх"*, 13.1.2-т *"эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах"*, 13.1.4-т *"даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх"*, 13.1-д *"эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын"*

гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. Тус төвийн захирал Эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийг тохиолдуулан 425 ажилтанд тус бүр 300.0 мянган төгрөг, нийт 127,500.0 мянган төгрөгийн урамшууллыг сар, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын гурав. Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал, 3.2-т “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно” гэсэн заалтууд, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4.2-т “байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад сар, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

3. Өмнөх оны жилийн эцсийн байдлаар хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой өр төлбөрөө барагдуулаагүй, жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өглөг 3,004,813.9 мянган төгрөг, бусад өглөгийн үлдэгдэл 676,643.5 мянган төгрөг болж, нийт өр төлбөр өмнөх оноос 2,085,481.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаанд нь төлөөгүй өр төлбөрийг 30.0 хүртэл хувиар барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4. “Индиа фарм” ХХК-д 2024 оны 8 дугаар сард 18,000.0 мянган төгрөг шилжүүлээд 5000 ширхэг эм авахаас 2500 ширхэг эмийг хүлээн авснаас 2024 онд 20 ширхэг, 2025 онд 292 ширхэг эмийг зарлагадаад 2025 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар 2188 ширхэг буюу 7,876.8 мянган төгрөгийн эмийн хугацаа нь дууссан, 6-7 жилийн ашиглалтгүй эмийн нөөц үүссэн байна. Мөн тус компанид эмийн үнэд 2024 оны 12 дугаар сард 96,600.0 мянган төгрөг шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн бөгөөд өнөөдрийг хүртэл тухайн компаниас эмээ хүлээж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Индиа фарм” ХХК-аас авах эмийн тооцоог бүрэн барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

5. Сэтгэцийн эмгэг судлал III-ын засварын ажилд шаардагдах 95,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй засварын материалын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар тендер зарлаж, “ЭМУР илч” ХХК-аас худалдан авсан гэх боловч бараа материалыг хүлээн авсан акт байхгүй, бараа материалын нэг бүрийн үнэ тодорхойгүй, орлогод авалгүй шууд зардал болгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авсан бараа материалыг орлогод авахгүйгээр шууд зардалд бичиж, нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, зааврыг зөрчсөн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

6. Нэр бүхий 10 байгууллага /сайт/-тай тус бүр 4,900.0 мянган төгрөгийн хэвлэл мэдээллийн гэрээ байгуулсан боловч бүх гэрээний гүйцэтгэгчийн нэр, дансны дугаараас бусад бүх заалт ижил, гэрээний дагуу нийт 49,000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч гүйцэтгэлийн тайлан байхгүй, гэрээг дүгнээгүй, хийсэн ажлын нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-аас баталсан хууль тогтоомж, ЗГ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

7. Байгууллагын 2025 оны Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгаагүй, 418,806.8 мянган төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгэх худалдан авах ажиллагааг нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаас зайлсхийж, 20,000.0 мянган төгрөгт багтаан хэсэгчлэн хувааж, 18 харилцагчтай 23 шууд худалдан авах гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Захиалагч ерөнхий гэрээний

аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 32 дугаар зүйлийн 32.1-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэн заалтууд, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гуравдугаар бүлэгт зааснаар тендер хянан үзэх, үнэлэхтэй холбоотой нарийвчилсан харилцаанд энэ аргачлал, зааврыг баримтална" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхээс зайлсхийж, төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

8. Итгэл-Анд ХХК-тай 2025 оны 4 дүгээр сард ажилтнууд, эмчлүүлэгчдэд халуун хоолоор үйлчлэх СЭМҮТ/20250103005 дугаартай гэрээ байгуулж, 2025 оны 4-12 сарын хугацаанд хоолны үнэд нийт 1,191,350.9 мянган төгрөг шилжүүлсэн. "Үйлчлүүлэгчид, ажилтнуудын эмчилгээний халуун хоол"-ны үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулснаар төсөвт ямар ч хэмнэлт гараагүй байна. Тендерт шалгарч гэрээ байгуулсан Итгэл-Анд ХХК нь хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа тус эмнэлгийн гал тогооны бүх тоног төхөөрөмжийг ашигладаг, ажилчдыг нь ажиллуулдаг боловч ажилчдын цалин урамшуулал болон ашиглалтын бүх зардлыг өнөөдрийг хүртэл Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хариуцаж, гэрээний хугацаанд ажилчдын цалин урамшуулалд 441,944.7 мянган төгрөг, цахилгааны зардалд 16,350.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "Үйлчлүүлэгчид, ажилтнуудын эмчилгээний халуун хоол" гэрээний гүйцэтгэгчийн эрх үүрэгт "эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг үзүүлэх хүчин чадал, мэргэшсэн боловсон хүчинтэй байх", Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал 2025 оны 7/234 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт "тодруулгын хариу" тодруулгын хүргүүлэхдээ тухайн цайны газарт ажиллах хүчний 22 ажилтны цалингийн зардал нь тендерийн үнэнд орсон, цэвэрлэгээ, хог тээвэр, ариутгал, хоол үйлдвэрлэлтэй холбоотой ус, цахилгаан, дулааны зардлыг гүйцэтгэгч тал хариуцна" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цайны газрын хоол үйлдвэрлэлтэй холбоотой гарч байгаа тогтмол зардлууд болон цалин урамшууллын зардлыг байгууллагын төсвөөс олгосон зөрчлийг таслан зогсоож, үйлчлүүлэгч, ажилтнуудын эмчилгээний халуун хоолоор үйлчлэх гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

9. Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан, албан тушаалтны гомдлын дагуу Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны хурлын тэмдэглэлийг үндэслэн 3 сарын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 9,539.7 мянган төгрөгийг төсвөөс нөхөн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу "гэм буруутай албан

тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хариуцан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Өмнөх онуудад элэгдэл байгуулж, элэгдлээрээ анхы ертгөө нөхсөн, актлагдаж данс бүртгэлээс хасагдсан болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоосон хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар хүлээн зөвшөөрч, тайлант оны санхүүгийн үр дүнг бууруулж тайлагнасан.	1	1,471,182.1			1	1,471,182.1	1	1,471,182.1				
2	Үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгө данснаас хассан гарзыг 25,834,953 төгрөгөөр илүү тайлагнаж тайлант хугацааны үр дүнг бууруулсан	1	25,834.9			1	25,834.9	1	25,834.9				
3	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 850.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй	1	850.000	1	850.0			1	850.0				
4	Тайлант онд худалдан авсан 19,882.0 мянган төгрөгийн үнэ бүхий 9 ш тоног төхөөрөмж, хивс зэргийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	19,882.0			1	19,882.0	1	19,882.0				
	Дүн	4	1,517,749.0	1	850.0	3	1,516,899.0	4	1,517,749.0				

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 104,394.9 мянган төгрөг хасагдсан, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	104,394.9			1	104,394.9						
2	Өмнөх оны жилийн эцсийн байдлаар ХХОАТ, НДШ-тэй холбоотой өр төлбөрөө барагдуулаагүй, жилийн эцсийн байдлаар НДШ, ХХОАТ-ийн өглөг 3.004.813.9 мянган төгрөг, бусад өглөгийн үлдэгдэл 676,643.5 мянган төгрөг болж, нийт өр төлбөр өмнөх оноос 2.085.481.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.	1	3,681,457.4			1	3,681,457.4						
3	Тайлант онд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй 11 ажилтанд нийт 7,456.1 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон.	1	7,456.1	1	7,456.1								
4	Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан, албан тушаалтны гомдлын дагуу Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гарван талт хорооны хурлын тэмдэглэлийг үндэслэн 3 сарын цалин, НДШ-д 9,539.7 мянган төгрөгийг төсвөөс олгосон.	1	9,539.7			1	9,539.7						
5	Захирлын 2025 оны А/259 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийг тохиолдуулан 425	1	127,500.0			1	127,500.0						

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ажилтанд тус бүр 300.0 мянган төгрөг олгохоор тушаал гаргаж, нийт 127,500.0 мянган төгрөгийн урамшууллыг сар, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон олгосон байна											
6	Индиа фарм ХХК-д 2024 оны 8 дугаар сард 18,000.0 мянган төгрөг шилжүүлээд 5000ш эм авахаас 2500 ш эмийг хүлээж авснаас 2024 онд 20ш, 2025 онд 292ш зарлагдаад 2025.05.30-нд байдлаар 2188ш /6-7 жилийн нөөц/ нийт 7,876.8 мянган төгрөгийн эмийн хугацаа нь дууссан байна. Мөн 2024 оны 12 дугаар сард эмийн үнэ гэж 96,600.0 мянган төгрөг шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн бөгөөд тухайн компаниас авах эмээ өнөөдрийг хүртэл хүлээж аваагүй байна.	1	104,476.8								1	104,476.8
7	Сэтгэцийн эмгэг судлал III засварын ажилд шаардагдах 95,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй засварын материалын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар тендер зарлаж, ЭМУР илч ХХК-аас худалдан авсан гэх боловч бараа материалыг хүлээн авсан акт байхгүй, бараа материалын нэг бүрийн үнэ тодорхойгүй, орлогот авалгүй шууд зардал болгосон	1	94,795.0			1	94,795.0					
8	Итгэлт- Анд ХХК-тай 2025 оны 4 дүгээр сард ажилтнууд, эмчлүүлэгчдэд халуун хоолоор үйлчлэх СЭМҮТ /20250103005 дугаартай гэрээ байгуулж, 2025 оны 4-12 сарын хугацаанд хоолны үнэнд нийт 1,191,350.9 мянган төгрөг шилжүүлсэн. "Үйлчлүүлэгчид, ажилтнуудын эмчилгээний халуун хоол" -ны үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулснаар төсөвт ямар ч хэмнэлт гараагүй байна. Тендерт шалгарч гэрээ байгуулсан Итгэл- Анд ХХК нь хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа тус эмнэлгийн гал тогооны бүх тоног төхөөрөмжийг ашигладаг, ажилчдыг нь ажиллуулдаг боловч ажилчдын цалин урамшуулал болон ашиглалтын бүх	1	458,295.2								1	458,295.2

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	зардлыг өнөөдрийг хүртэл СЭМҮТ хариуцаж, гэрээний хугацаанд ажилчдын цалин урамшуулалд 441,944.7 мянга, цахилгааны зардалд 16,350.5 мянган төгрөг зарцуулсан байна.												
9	Нэр бүхий 1 байгууллага /сайт/-тай 4,900.0 мянган төгрөгийн хэвлэл мэдээллийн гэрээ байгуулж, мөнгийг нь бүрэн шилжүүлсэн боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна	1	4,900.0	1	4,900.0								
10	Нэр бүхий 10 байгууллага /сайт/-тай тус бүр 4,900.0 мянган төгрөгийн хэвлэл мэдээллийн гэрээ байгуулсан боловч бүх гэрээний гүйцэтгэгчийн нэр, дансны дугаараас бусад бүх заалт ижил, гэрээний дагуу нийт 49,000.0 төгрөг шилжүүлсэн боловч гүйцэтгэлийн тайлан байхгүй, гэрээг дүгнээгүй, хийсэн ажлын нотлох баримт хангалтгүй байна	1	49,000.0			1	49,000.0						
11	Байгууллагын 2025 оны Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгаагүй, 418,806.8 мянган төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгэх худалдан авах ажиллагааг нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаас зайлсхийж, 20.0 сая төгрөгт багтаан хэсэгчлэн хувааж, 18 харилцагчтай 23 шууд худалдан авах гэрээ байгуулж ажилласан	1	418,806.8			1	418,806.8						
12	"Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний санхүүжилтээс Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/236 дугаар тушаалаар баталсан "үндэсний хөдөлгөөний хүрээнд" хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй шүдний эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ гэсэн арга хэмжээнд нийт 25,000.0 мянган төгрөгийг хэдэн сард, хаана, хэдэн хүнд ямар үйлчилгээ үзүүлснийг нотлох анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.	1	25,000.0	1	25,000.0								
	2025 оны 1-3 дугаар сард 3 компанитай ("Өндөр цалгай транс" ХХК, "ГОТИК												

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	ГОЛД РӨҮД" ХХК-иудтай засварын ажил гүйцэтгүүлэх, "Гранд локита" ХХК -тай гал тогооны ширээ, сандал хийлгэх) тус тус "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, төлбөрийг 100 хувь шилжүүлсэн боловч эдгээр ажлууд өнөөдрийг хүртэл хийгдээгүй байхад тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.	1	56,390.5	1	56,390.5								
Дүн		13	5,142,012.5	4	93,746.6	7	4,485,493.9					2	562,772.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 152 мэдээллээс 4 мэдээллийг, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 297,997.7 мянган төгрөгийн зарлагын 14 гүйлгээ, 26,163.0 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг тус тус байршуулаагүй, 3,279,244.2 мянган төгрөгийн зарлагын 177 гүйлгээ, 15,823,240.5 мянган төгрөгийн орлогын 42 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан, тушаал, шийдвэр гэх мэт зарлагын гүйлгээний хавсралтуудыг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.	1	19,426,535.4	1	19,426,535.4		
Дүн		1	19,426,535.4	1	19,426,535.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	Худалдан авах төлөвлөгөөний дагуу 28 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 6 худалдан авах ажиллагааны ҮХ-ний хурлын тэмдэглэл дутуу, тендер үнэлэх журмын дагуу маягтуудыг нөхөж үнэлээг хийгээгүй, оролцогчийн санхүүгийн, хүний нөөцийн чадавхыг үнэлэхэд шаардлагатай нотлох баримтууд дутуу					1	-
Дүн		1				1	-
Нийт дүн		2	19,426,535.4	1	19,426,535.4	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 51/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/206/НА - СТА - ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний санхүүжилтээс Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/236 дугаар тушаалаар баталсан "үндэсний хөдөлгөөний хүрээнд" хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй шүдний эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ гэсэн арга хэмжээнд Шүдний эрүүл мэнд, боловсрол олгох Дагинас үндэсний санд 19,862,000.00 /арван есөн сая найман зуун жаран хоёр мянган/ төгрөг, "РТА" ХХК-д 5,138,000.00 /таван сая нэг зуун гучин найман мянган/ төгрөг, нийт 25,000,000.00 /хорин таван сая/ төгрөгийг хэдэн сард, хаана, хэдэн хүнд ямар үйлчилгээ үзүүлснийг нотлох анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйл 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтууд болон Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/236 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7 "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Эрүүл мэндийн сайдын баталсан төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээнд анхан шатны баримтгүй зарцуулсан нийт 25,000,000.00 (Хорин таван сая) төгрөгийг "Шүдний эрүүл мэнд, боловсрол олгох Дагинас үндэсний сан" болон "РТА" ХХК-аар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

АТА10007
9025031411

Z:\Akt\2026\0225-SAG-25.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 50/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төв нь сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй хавсралтад дурдсан 11 ажилтанд 7,456,126.00 /Долоон сая дөрвөн зуун тавин зургаан мянга нэг зуун хорин зургаан/ төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын "Журам батлах тухай" 2019 оны 5 дугаар тогтоолын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтууд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 8.7-д "Төвийн захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жилийн дараа ажилтанд дараах эрх үүснэ", 8.7.2-т "Шагнал, урамшуулал авах", 8.21.6-д "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д гэсэн заалтыг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад олгосон 7,456,126.00 /Долоон сая дөрвөн зуун тавин зургаан мянга нэг зуун хорин зургаан/ төгрөгийг хавсралтад дурдсан нэр бүхий 11 ажилтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 49/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2025 оны 1-3 дугаар сард 3 компанитай "Өндөр цалгай транс" ХХК-д 19,375,500.00 /арван есөн сая гурван зуун далан таван мянга таван зуун/ төгрөг, "ГОТИК ГОЛД РӨҮД" ХХК-д 18,761,000.00 /арван найман сая долоон зуун жаран нэгэн мянган/ төгрөгийг засварын ажил гүйцэтгүүлэхээр, "Гранд локита" ХХК-д 18,254,000.00 /арван найман сая хоёр зуун тавин дөрвөн мянган/ төгрөгийг гал тогооны ширээ, сандал хийлгэхээр "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, төлбөрийг 100 хувь шилжүүлсэн боловч эдгээр ажлууд өнөөдрийг хүртэл хийгдээгүй байхад тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй, актаар хүлээж аваагүй засварын ажилд шилжүүлсэн нийт 56,390,500.00 (Тавин зургаан сая гурван зуун ерэн мянга таван зуун) төгрөгийг "Өндөр цалгай транс" ХХК, "ГОТИК ГОЛД РӨҮД" ХХК, "Гранд локита" ХХК-уудаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAГ-25.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 48/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“НКСТ ЭРА” ХХК-аар мэдээ, мэдээлэл, хэвлэл, контент хийлгэхээр гэрээ байгуулж 4,900,000.00 /дөрвөн сая есөн зуун мянган/ төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлын гүйцэтгэл байхгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.7 “төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх нэр бүхий компанид мэдээ, мэдээлэл, хэвлэл, контент хийлгэхээр шилжүүлсэн 4,900,000.00 /Дөрвөн сая есөн зуун мянган/ төгрөгийг “НКСТ ЭРА” ХХК-иар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30 ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 268/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Байгууллагын 2025 оны Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгаагүй, 418,806,800.00 /дөрвөн зуун арван найман сая найман зуун зургаан мянга найман зуун/ төгрөгийн урсгал засварын ажил гүйцэтгэх худалдан авах ажиллагааг нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаас зайлсхийж, 20,000,000.00 /хорин сая/ төгрөгт багтаан хэсэгчлэн хувааж, 18 харилцагчтай 23 шууд худалдан авах гэрээ байгуулсан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 32 дугаар зүйлийн 32.1-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэн заалтууд, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гуравдугаар бүлэгт зааснаар тендер хянан үзэх, үнэлэхтэй холбоотой нарийвчилсан харилцаанд энэ аргачлал, зааврыг баримтална" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхээс зайлсхийж, төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгэж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 267/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/206/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Итгэл- Анд ХХК-тай 2025 оны 4 дүгээр сард ажилтнууд, эмчлүүлэгчдэд халуун хоолоор үйлчлэх СЭМҮТ/20250103005 дугаартай гэрээ байгуулж, 2025 оны 4-12 сарын хугацаанд хоолны үнэнд нийт 1,191,350,940.00 /Нэг тэрбум нэг зуун ерэн нэгэн сая гурван зуун тавин мянга есөн зуун дөчин/ төгрөг шилжүүлсэн. "Үйлчлүүлэгчид, ажилтнуудын эмчилгээний халуун хоол"-ны үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулснаар төсөвт ямар ч хэмнэлт гараагүй байна. Тендерт шалгарч гэрээ байгуулсан Итгэл- Анд ХХК нь хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа тус эмнэлгийн гал тогооны бүх тоног төхөөрөмжийг ашигладаг, ажилчдыг нь ажиллуулдаг боловч ажилчдын цалин урамшуулал болон ашиглалтын бүх зардлыг өнөөдрийг хүртэл Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хариуцаж, гэрээний хугацаанд ажилчдын цалин урамшуулалд 441,944,700.00 /Дөрвөн зуун дөчин нэгэн сая есөн зуун дөчин дөрвөн мянга долоон зуун/ төгрөг, цахилгааны зардалд 16,350,500.00 /Арван зургаан сая гурван зуун тавин мянга таван зуун/ төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "Үйлчлүүлэгчид, ажилтнуудын эмчилгээний халуун хоол" гэрээний гүйцэтгэгчийн эрх үүрэгт "эмнээгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг үзүүлэх хүчин чадал, мэргэшсэн боловсон хүчинтэй байх", Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал 2025 оны 7/234 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт "тодруулгын хариу" хүргүүлэхдээ "тухайн цайны газарт ажиллах хүчний 22 ажилтны цалингийн зардал нь тендерийн үнэнд орсон, цэвэрлэгээ, хог тээвэр, ариутгал, хоол үйлдвэрлэлтэй холбоотой ус, цахилгаан, дулааны зардлыг гүйцэтгэгч тал хариуцна" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цайны газрын хоол үйлдвэрлэлтэй холбоотой гарч байгаа тогтмол зардлууд болон цалин урамшууллын зардлыг байгууллагын төсвөөс олгосон зөрчлийг таслан зогсоож, үйлчлүүлэгч, ажилтнуудын эмчилгээний халуун хоолоор үйлчлэх гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.НАСАНБУЯН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 266/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/206/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 104,394,900.00 /Нэг зуун дөрвөн сая зурван зуун ерэн дөрвөн мянга есөн зуун/ төгрөг хасагдсан, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-т "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, дотоод хяналтыг сайжруулах, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг 30.0 хувь хүртэл бууруулж, үр дүнг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026/0125 SA-G-32.Docx

1526180569



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 265/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/206/НА - СТА - ТИ 3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирлын А/259 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийг тохиолдуулан 425 ажилтанд тус бүр 300,000.00 /Гурван зуун мянган/ төгрөг, нийт 127,500,000.00 /Нэг зуун хорин долоон сая таван зуун мянган/ төгрөгийн мөнгөн урамшууллыг сар, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын гурав. Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал, 3.2-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно" гэсэн заалтууд, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажилтнуудад сар, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 264/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026 /206/ ИА - СТА - ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд ил тод байршуулбал зохих нийт 152 мэдээллээс 4 мэдээллийг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 297,997,700.00 /хоёр зуун ерэн долоон сая есөн зуун ерэн долоон мянга долоон зуу/ төгрөгийн зарлагын 14 гүйлгээ, 26,163,000.00 /хорин зургаан сая нэг зуун жаран гурван мянга/ төгрөгийн орлогын 1 гүйлгээг тус тус байршуулаагүй, 3,279,244,200.00 /гурван тэрбум хоёр зуун далан есөн сая хоёр зуун дөчин дөрвөн мянга хоёр зуу/ төгрөгийн зарлагын 177 гүйлгээ, 15,823,240,500.00 /Арван таван тэрбум найман зуун хорин гурван сая хоёр зуун дөчин мянга, таван зуу/ төгрөгийн орлогын 42 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан, тушаал, шийдвэр гэх мэт зарлагын гүйлгээний хавсралтуудыг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд ил тод тавих мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй эдийн засагч Д.Мөнхтуулд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлэхийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/-т хариуцуулав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

ЦНАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 263/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА-СТА-ТЦ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 10 байгууллага /сайт/-тай тус бүр 4,900,000.00 /дөрвөн сая есөн зуун мянган/ төгрөгийн хэвлэл мэдээллийн гэрээ байгуулсан боловч бүх гэрээний гүйцэтгэгчийн нэр, дансны дугаараас бусад бүх заалт ижил гэрээний дагуу нийт 49,000,000.00 /дөчин есөн сая/ төгрөг шилжүүлсэн боловч гүйцэтгэлийн тайлан байхгүй, гэрээг дүгнээгүй, хийсэн ажлын нотлох баримт хангалтгүй байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-аас баталсан хууль тогтоомж, ЗГ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
ВЭРДЭНЭЦОГ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3. Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga.2026.0125.SAG-32.Docx

152618057



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 262 /А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Индиа фарм" ХХК-д 2024 оны 8 дугаар сард 18,000,000.00 /арван найман сая/ төгрөг шилжүүлээд 5000 ширхэг эм авахаас 2500 ширхэг эмийг хүлээн авснаас 2024 онд 20 ширхэг, 2025 онд 292 ширхэг эмийг зарлагдаад 2025 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар 2188 ширхэг буюу 7,876.800.00 /долоон сая найман зуун далан зургаан мянга найман зуун/ төгрөгийн эмийн хугацаа нь дууссан, 6-7 жилийн ашиглалтгүй эмийн нөөц үүссэн байна. Мөн тус компанид эмийн үнэн 2024 оны 12 дугаар сард 96,600,000.00 /Ерэн зургаан сая зургаан зуун мянган/ төгрөг шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн бөгөөд өнөөдрийг хүртэл тухайн компаниас эмээ хүлээж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж аялага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Индиа фарм" ХХК-иас авах эмийн тооцоог бүрэн барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3; Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga-2026\0125 SAG-32.Docx

152618057



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 261/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэтгэцийн эмгэг судлал III-ын засварын ажилд шаардагдах 95,000,000.00 /ерэн таван сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй засварын материалын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар тендер зарлаж, "ЭМУР илч" ХХК-аас худалдан авсан гэх боловч бараа материалыг хүлээн авсан акт байхгүй, бараа материалын нэг бүрийн үнэ тодорхойгүй, орлогод авалгүй шууд зардал болгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авсан бараа материалыг орлогод авахгүйгээр шууд зардалд бичиж, нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, зааврыг мөрдөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 260/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны жилийн эцсийн байдлаар хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой өр төлбөрөө барагдуулаагүй, жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өглөг 3,004,813,938.00 /гурван тэрбум дөрвөн сая найман зуун арван гурван мянга есөн зуун гучин найман/ төгрөг, бусад өглөгийн үлдэгдэл 676,643,526.00 /зургаан зуун далан зургаан сая зургаан зуун дөчин гурван мянга таван зуун хорин зургаан/ төгрөг болж, нийт өр төлбөр өмнөх оноос 2,085,481,840.00 /хоёр тэрбум наян таван сая дөрвөн зуун наян нэгэн мянга найман зуун дөчин/ төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаанд нь төлөөгүй, өр төлбөрийг 30 хүртэл хувиар барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 259/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/206/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан, албан тушаалтны гомдлын дагуу Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны хурлын тэмдэглэлийг үндэслэн 3 сарын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 9,539,710.00 /Есөн сая таван зуун гучин есөн мянга долоон зуун арван/ төгрөгийг төсвөөс нөхөн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу “гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод, аудитын газар хариуцан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Янжмаа/, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Г.Ууганцэцэг/, Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Анхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭРДЭНЭЦОГТ
Л.НАСАНБУЯН